

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өвөрхангай аймгийн Музей 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ӨВА-2022/98/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Арвайхээр

2022 он

Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: BatjargalO@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Гансүх

Утас: 70323833 Цахим хаяг: GansukhD@audit.gov.com

Ахлах аудитор: С.Шийлэгмаа

Утас: 70323833 Цахим хаяг: Shiilegmaas@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Аудитын тайлан
- 3.1 Ерөнхий зүйл
- 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
- 3.4 Материаллаг байдал.....
- 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....
- 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....
- 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг
- 3.8 Аудитын гол асуудал.....
- 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
4. Аудитын илрүүлэлт.....
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

1. Аудитын дүгнэлт



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,
Утас/Факс: (976) 7032 3253,
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2022.01.11 № 06
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

МУЗЕЙН ДАРГА
Д.ТОГТОХ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 -д заасны дагуу Аймгийн Музей 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Музей 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Музей 2021 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотсод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй

015030010

D:\Audiitiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл /төгрөгөөр/

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Музей

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2021 оны 12-р сарын 31-ний өдөр

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	21.363.171.00	22.104.128.00
35	БАРАА МАТЕРИАЛ	21.363.171.00	22.104.128.00
35100	Түүхий эд материал	1.245.577.00	968.884.00
35110	Тусгай зориулалттай материал	1.245.577.00	968.884.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	43.000.00	7.700.00
35400	Хангамжийн материал	20.074.594.00	21.127.544.00
35410	Бичиг хэргийн материал	1.357.359.00	1.709.649.00
35420	Аж ахуйн материал	6.573.495.00	6.473.255.00
35430	Сэлбэг хэрэгсэл	565.000.00	565.000.00
35440	Түлш, шатах тослох материал	-	1.672.000.00
35450	Барилгын засварын материал	8.439.600.00	8.232.100.00
35470	Бусад хангамжийн материал	3.139.140.00	2.475.540.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1.717.305.885.76	1.682.491.266.76
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1.717.305.885.76	1.682.491.266.76
39200	Биет хөрөнгө	1.650.200.635.66	1.615.441.016.62
39201	Барилга, байгууламж, орон сууц	548.136.160.70	548.136.160.70
39202	Хуримтлагдсан элэгдэл -	(62.639.233.44)	(93.002.600.16)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	44.900.000.00	14.900.000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл -	(31.986.666.72)	(13.658.333.26)
39205	Машин тоног	33.266.878.75	43.876.878.75
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног	(19.172.454.02)	(22.684.430.47)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	25.689.970.51	25.689.970.51
39208	Хуримтлагдсан элэгдэл -	(16.345.820.12)	(18.968.429.45)
39213	Түүх соёл, музейн дурсгалт	1.126.360.200.00	1.129.160.200.00
39217	Номын фонд	1.991.600.00	1.991.600.00
39300	Биет бус хөрөнгө	67.105.250.10	67.050.250.14
39301	Програм хангамж	550.000.00	550.000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл -	(178.749.90)	(233.749.86)
39303	Бусад биет бус хөрөнгө	66.734.000.00	66.734.000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	1.738.669.056.76	1.704.595.394.76
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)	0.00	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
41300	Өглөг	0.00	0.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	0.00
41312	НДШ-ийн өглөг	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	1.738.669.056.76	1.704.595.394.76
51	Засгийн газрын хувь оролцоо	1.738.669.056.76	1.704.595.394.76
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон	393.423.685.58	393.423.685.58
51200	Хуримтлагдсан үр дүн	1.264.130.127.68	1.230.056.465.68
51210	Өмнөх үеийн үр дүн	1.296.823.522.02	1.254.941.794.42
51220	Тайлант үеийн үр дүн	(32.693.394.34)	(24.885.328.74)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний	81.115.243.50	81.115.243.50
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ	1.738.669.056.76	1.704.595.394.76

**Аймгийн Музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Музей

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2021 оны 12-р сарын 31-ний өдөр

Код	Үзүүлэлт	Өмнөх жилийн дүн	Тайлант жилийн дүн
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	226.167.018.50	234.508.400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3.169.318.50	10.100.000.00
1200	Нийтлэг татварын бус орлого	3.169.318.50	10.100.000.00
120009	Бусад нийтлэг татварын бус орлого	3.169.318.50	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн	-	10.100.000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	222.997.700.00	224.408.400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	856.000.00	196.000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	856.000.00	196.000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	222.141.700.00	224.212.400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн	222.141.700.00	216.695.700.00
132002	Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	-	7.516.700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	258.860.412.84	259.393.728.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	258.860.412.84	259.393.728.74
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	258.192.706.94	259.381.595.44
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	138.394.336.00	143.679.700.00
210101	Үндсэн цалин	116.650.692.00	111.443.634.00
210102	Нэмэгдэл	21.743.644.00	32.236.066.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17.313.994.10	19.387.293.34
210201	Тэтгэврийн даатгал	12.010.320.16	13.592.632.46
210202	Тэтгэмжийн даатгал	1.064.299.95	1.484.260.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	1.208.199.93	1.149.400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	248.360.59	287.400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2.782.813.47	2.873.600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50.755.757.00	48.538.177.95
210301	Гэрэл, цахилгаан	1.121.520.00	940.657.95
210302	Түлш, халаалт	49.304.887.00	47.228.280.00
210303	Цэвэр, бохир ус	329.350.00	369.240.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7.695.435.00	6.148.538.41
210401	Бичиг хэрэг	307.790.00	678.220.00
210402	Тээвэр, шатахуун	2.492.000.00	1.650.000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1.231.544.00	943.470.41
210404	Ном, хэвлэл	270.000.00	180.000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал,	280.000.00	660.000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3.114.101.00	1.922.573.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	114.275.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2.481.300.00	427.500.00
210604	Урсгал засвар	2.481.300.00	427.500.00
2107	Томилолт, зочны зардал	1.018.400.00	580.000.00
210702	Дотоод албан томилолт	1.018.400.00	580.000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний	1.253.500.00	881.000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил	288.000.00	240.472.00
210803	Даатгалын үйлчилгээ	174.000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	125.000.00	62.300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55.000.00	-
210807	Газрын төлбөр	611.500.00	578.228.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39.279.984.84	39.739.385.74
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3.977.250.00	703.100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	35.302.734.84	39.036.285.74
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	667.705.90	12.133.30
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад	167.705.90	12.133.30
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	167.705.90	12.133.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	500.000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500.000.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(32.693.394.34)	(24.885.328.74)
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	(32.693.394.34)	(24.885.328.74)

**Аймгийн Музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2.2 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Музей

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2021 оны 12-р сарын 31-ний өдөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Бусад	НИЙТ ДҮН
1	ҮЛДЭГДЭЛ	-	-	-	-	-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын	-	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз	-	-	-	-	-
7	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	-
8	ҮЛДЭГДЭЛ	393.423.685.58	81.115.243.50	1.264.130.127.68	-	1.738.669.056.76
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын	-	-	(9.188.333.26)	-	(9.188.333.26)
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	393.423.685.58	81.115.243.50	1.254.941.794.42	-	1.729.480.723.50
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-	-
12	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-	-
13	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз	-	-	-	-	-
14	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
15	Тайлант үеийн үр дүн	-	-	(24.885.328.74)	-	(24.885.328.74)
16	ҮЛДЭГДЭЛ	393.423.685.58	81.115.243.50	1.230.056.465.68	-	1.704.595.394.76

Аймгийн Музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Музей			
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН			
2021 оны 12-р сарын 31-ний өдөр			
Код	Үзүүлэлт	Өмнөх жилийн дүн	Тайлант жилийн дүн
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	222.997.700.00	224.408.400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	222.997.700.00	224.408.400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	856.000.00	196.000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	856.000.00	196.000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	222.141.700.00	224.212.400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон	222.141.700.00	216.695.700.00
132002	Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	-	7.516.700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	222.997.700.00	221.098.400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	222.997.700.00	221.098.400.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	222.329.994.10	221.086.266.70
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	138.394.336.00	143.679.700.00
210101	Үндсэн цалин	116.650.692.00	111.443.634.00
210102	Нэмэгдэл	21.743.644.00	32.236.066.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх	17.313.994.10	19.387.293.34
210201	Тэтгэврийн даатгал	12.010.320.16	13.640.093.34
210202	Тэтгэмжийн даатгал	1.064.299.95	1.436.800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1.208.199.93	1.149.400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	248.360.59	287.400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2.782.813.47	2.873.600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50.755.757.00	48.538.177.95
210301	Гэрэл, цахилгаан	1.121.520.00	940.657.95
210302	Түлш, халаалт	49.304.887.00	47.228.280.00
210303	Цэвэр, бохир ус	329.350.00	369.240.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6.475.107.00	7.016.995.41
210401	Бичиг хэрэг	770.000.00	853.000.00
210402	Тээвэр, шатахуун	2.492.000.00	3.322.000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1.231.544.00	943.470.41
210404	Ном, хэвлэл	300.000.00	300.000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн	280.000.00	660.000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1.401.563.00	938.525.00
2105	Нормативт зардал	371.600.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	371.600.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2.000.000.00	300.000.00
210604	Урсгал засвар	2.000.000.00	300.000.00
2107	Томилолт, зочны зардал	1.018.400.00	580.000.00
210702	Дотоод албан томилолт	1.018.400.00	580.000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний	1.385.500.00	881.000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил	420.000.00	240.472.00
210803	Даатгалын үйлчилгээ	174.000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	125.000.00	62.300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55.000.00	-
210807	Газрын төлбөр	611.500.00	578.228.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4.615.300.00	703.100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4.615.300.00	703.100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	667.705.90	12.133.30
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад	167.705.90	12.133.30
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	167.705.90	12.133.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	500.000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500.000.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III-I-	-	3.310.000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	3.310.000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	3.310.000.00
223	БУСАД ХӨРӨНГӨ	-	3.310.000.00
223004	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	3.310.000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	(3.310.000.00)

**Аймгийн Музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2.4 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Музей					
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН					
2021 оны 12-р сарын 31-ний өдөр					
Код	Үзүүлэлт	Тайлан он		Зөрүү	
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Дүнгээр	Хувиар
11000	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	-	-	-	-
71702	Соёл урлаг	216.695.700.00	216.695.700.00	(0.00)	100.00
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	216.695.700.00	216.695.700.00	(0.00)	100.00
12	Татварын бус орлого	216.695.700.00	216.695.700.00	(0.00)	100.00
122	Тусламж, санхүүжилтийн орлого	216.695.700.00	216.695.700.00	(0.00)	100.00
122005	Төсвөөс санхүүжих	216.695.700.00	216.695.700.00	(0.00)	100.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	216.695.700.00	216.695.700.00	(0.00)	100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	216.695.700.00	216.683.566.70	12.133.30	99.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	216.695.700.00	216.683.566.70	12.133.30	99.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	143.679.700.00	143.679.700.00	-	100.00
210101	Үндсэн цалин	121.200.000.00	111.443.634.00	9.756.366.00	91.95
210102	Нэмэгдэл	22.479.700.00	32.236.066.00	(9.756.366.00)	143.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд	19.396.800.00	19.387.293.34	9.506.66	99.95
210201	Тэтгэврийн даатгал	13.649.600.00	13.640.093.34	9.506.66	99.93
210202	Тэтгэмжийн даатгал	1.436.800.00	1.436.800.00	0.00	99.99
210203	ҮОМШӨ-ний даатгал	1.149.400.00	1.149.400.00	(0.00)	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	287.400.00	287.400.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2.873.600.00	2.873.600.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол	46.380.800.00	46.378.177.95	2.622.05	99.99
210301	Гэрэл, цахилгаан	1.008.000.00	940.657.95	67.342.05	93.31
210302	Түлш, халаалт	44.919.200.00	45.068.280.00	(149.080.00)	100.33
210303	Цэвэр, бохир ус	453.600.00	369.240.00	84.360.00	81.40
2104	Хангамж, бараа материалын зардал	5.037.000.00	5.036.995.41	4.59	99.99
210401	Бичиг хэрэг	545.000.00	545.000.00	-	100.00
210402	Тээвэр, шатахуун	1.650.000.00	1.650.000.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн	1.080.000.00	943.470.41	136.529.59	87.35
210404	Ном, хэвлэл	300.000.00	300.000.00	-	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	660.000.00	660.000.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд	802.000.00	938.525.00	(136.525.00)	117.02
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	300.000.00	300.000.00	-	100.00
210604	Урсгал засвар	300.000.00	300.000.00	-	100.00
2107	Томилолт, зочны зардал	580.000.00	580.000.00	-	100.00
210702	Дотоод албан томилолт	580.000.00	580.000.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээнийн төлбөр, хураамж	618.300.00	618.300.00	-	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	62.300.00	62.300.00	-	100.00
210807	Газрын төлбөр	556.000.00	556.000.00	-	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	703.100.00	703.100.00	-	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	703.100.00	703.100.00	-	100.00
12000	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-

2.5 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Музей			
НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН			
2021 оны 12-р сарын 31-ний өдөр			
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлан он
11000	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	-	-
71702	Соёл урлаг	-	7.712.700.00
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	-	7.712.700.00
	Татварын бус орлого	-	7.516.700.00
	Тусламж, санхүүжилтийн орлого	-	7.516.700.00
	Төсвөөс санхүүжих	-	7.516.700.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	7.712.700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	7.712.700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	7.712.700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	2.160.000.00
210302	Түлш, халаалт	-	2.160.000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	2.490.000.00
210401	Бичиг хэрэг	-	308.000.00
210402	Тээвэр, шатахуун	-	1.672.000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	510.000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний	-	3.062.700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	-	3.040.472.00
210807	Газрын төлбөр	-	22.228.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	196.000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	196.000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	196.000.00
12000	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Аймгийн Музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд зөвлөмж өгөгдөөгүй болно.

Аудитыг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын ахлах аудитор С.Шийлэгмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Гансүх, газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Аймгийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 02 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Аймгийн Музейн нь Соёлын үйл ажиллагаа явуулдаг, Түүх соёлын өвийг цуглуулан хадгалах хамгаалах судлах сурталчлан таниулах эх оронч сэтгэлгээ төлөвшүүлэх танин мэдэхүй мэдлэг боловсролыг хөгжүүлэхэд оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын зохион байгуулалтын бүтцэд дотоод аудитын нэгж байхгүй.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Музейн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 259.04 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 2.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70.0 хувь буюу 1.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгө, бараа материалын болон авлага, өглөгийн тодруулгыг бэлтгэжээ:

- Үндсэн хөрөнгө оны эхнээс 16.6 сая төгрөгөөр буурсан байгаа нь автомашин акталсан байна.

- Бараа материалын үлдэгдэлд материаллаг өөрчлөлт орсон, 740.9 мянган төгрөгөөр өссөн.
- Урьд онд болон тайлант онд өглөг, авлагын үлдэгдэл байхгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төслийг хуулийн хугацаанд бэлтгэж, аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст нэгтгүүлж ирсэн байна. 2021 оны төсвийн төсөлд нийт зардлыг 216.7 сая төгрөгөөр төлөвлөсөн ба санхүүжилт 216.7 сая төгрөгөөр батлагджээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайланд оны төсөв 216.7 сая төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 216.7 сая төгрөгийн санхүүжилт ирсэн ба үүнээс 12,133 төгрөгийн хэмнэлтийг буцаан төвлөрүүлжээ. Оны нийт төсвийн гүйцэтгэл 216.7 сая төгрөг байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Музейн нэмэлт санхүүжилт тайлант онд 7.7 сая төгрөг, тухайлбал:

- ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан -7.5 сая төгрөг,
- Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого -0,19 сая төгрөг тус тус орж, зориулалтын дагуу зарцуулагджээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

3.8 Аудитын гол асуудал

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим, сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Төлөвлөлтийн шатанд 2 чиглэлээр 9 горим сорил хэрэгжүүлж, гүйцэтгэлийн шатанд 4 чиглэлээр аудитын 2 горим сорил нийт 11 горим сорил гүйцэтгэхэд алдаа зөрчил илрээгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аймгийн Музейн нь шилэн дансны цахим хуудсанд нийт 150 мэдээлэл байршуулахаас 144 мэдээллийг хугацаанд нь, 5 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан ба санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг байршуулах хугацаа болоогүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол зэрэг бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шалгасан зүйлсийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэсэн болно.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгч хэрэгжилтийг хугацаанд нь 100 хувь хэрэгжүүлсэн байна.

3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Байхгүй

3. Аудитын илрүүлэлт
байхгүй

4.1 Залруулсан алдаа

Залруулсан алдаа байхгүй.

4.2 Төлбөрийн акт

Акт тавигдаагүй.

4.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөөгүй.

4.4 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Аймгийн Музейн										

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

Д.ГАНСҮХ

С.ШИЙЛЭГМАА